



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар A/192

Мөрөн сүм

Захирамжийн холбогдох хэсгийг  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6, 60 дугаар зүйлийн 60.1.1, 61 дүгээр зүйлийн 61.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Захиргааны өрөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшил газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй Хатгал тосгон, 1 дүгээр хороо, Цахир толгойн зүүн хойно, Мөнх тур жуулчны баазын баруун талд байршилтай, үйлчилгээний зориулалттай 0.5 га газрыг "Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба"-д эзэмшүүлсэн Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/125 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан "Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба"-ны газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т даалгасугай.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдеж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН